

Аудитын код: САГ-2018/18/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Монгол улсын ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунбилэг

Утас: Цахим хаяг: oyunbilegs@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: hkosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг

Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа

Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

| | |
|---|----|
| | 0 |
| 1 Аудитын тайлан..... | 1 |
| 1.1 Оршил..... | 1 |
| 1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл..... | 1 |
| 1.3 Байгууллагын хууль, эрх зүйн орчин..... | 2 |
| 1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа..... | 2 |
| 1.5 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 2 |
| 1.6 Дотоод хяналт..... | 3 |
| 1.7 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 4 |
| 1.8 Шилэн дансны мэдээлэл..... | 5 |
| 1.9 Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар..... | 5 |
| 1.10 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар..... | 5 |
| 1.10.1 Харьяа газруудад нийт 3,262.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна..... | 5 |
| 1.10.2 Аймаг орон нутгийн нисэх буудлууд санхүүгийн тайлангаа батлагдсан маягтаар гаргаагүй..... | 5 |
| 1.10.3 Үр ашиггүй сургалтын зардал гаргасан..... | 6 |
| 1.10.4 Шүүхийн шийдвэрийн дагуу нийт 449.5 сая төгрөг төлсөн..... | 6 |
| 1.10.5 Сэргээн засах амралтын газар олон жил болсон авлагыг барагдуулаагүй байна6 | |
| 1.10.6 Сэргээн засах амралтын газрын хөрөнгө дутагдсан байна..... | 6 |
| 1.10.7 Сэргээн засах амралтын газрын мөнгөн гүйлгээний тайлан санхүүгийн програмын тохиргоотой холбоотойгоор орлогыг давхардуулж тайлагнасан байна..... | 7 |
| 1.10.8 Хөрөнгө оруулалтын ажлын гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээн аваагүй байна..... | 7 |
| 1.10.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ажил дуусаагүй, авлагын дансанд бүртгэлтэй байна..... | 7 |
| 1.10.10 Сэргээн засалт амралтын газарт АСЕМ зохион байгуулагдахад шилжиж ирсэн хөрөнгө дутагдсан байна..... | 7 |
| 1.10.11 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийн өглөгийн үлдэгдэл байна..... | 8 |
| 1.11 Залруулагдаагүй алдааны талаарх тайлбар..... | 8 |
| 1.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал..... | 8 |
| 1.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд..... | 9 |
| 1.14 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл..... | 9 |
| 1.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 9 |
| 1.16 Материаллаг байдал..... | 10 |
| 1.17 Зөрчилгүй санал дүгнэлт..... | 10 |
| 1.18 Аудитын үр өгөөж..... | 11 |
| 2 Менежментийн захидал..... | 11 |
| 2.1 Асуудал 1: Үр ашиггүй сургалтын зардал гаргасан..... | 12 |

01

ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | |
|-----|---|----|
| 2.2 | Асуудал 2: Харьяа газруудад илэрсэн зөрчлийн талаар | 12 |
| 2.3 | Асуудал 3: Сэргээн засах амралтын газрын хөрөнгө дутагдсан байна..... | 13 |
| 2.4 | Асуудал 4: Аймаг орон нутгийн санхүүгийн тайлангийн талаар | 13 |
| 3 | Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэнтайлан | 14 |
| 3.1 | Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан..... | 14 |
| 3.2 | Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан..... | 15 |
| 3.3 | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан | 16 |
| 3.4 | Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан..... | 17 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН
ТАНАА

2018. 03. 23 № 01/819
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG39.Docx

071475

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын СТОУС, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 12 дугаар сарын 1-ээс 2018 оны 3 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг, П.Амарсанаа нар гүйцэтгэв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/708 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1.3 БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Байгууллагын удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Татварын тухай, Улсын нисэхийн тухай, Иргэний нисэхийн тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль болон бусад холбогдолтой хууль, эрх зүйн актын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, дээрх зарим хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.

1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно, 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно”, 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 15.4.2-т “энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу “Иргэний нисэхийн ерөнхий газар”-ын дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлагийн төсвийг 2017 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвөөс, үйлдвэрлэлийн албадын төсвийг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталж навигацийн орлогоор санхүүжүүлдэг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

1.5 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлсэн.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 26 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Иргэний нисэхийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад салбарын хэмжээнд 2013 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна. Гэвч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах шаардлагатай байсан Үүнд:

- Салбарын онцлогт тохирсон гол хэрэглэгддэг дансны бичилт
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэр
- Шинээр батлагдсан хууль, журам, стандарт (СТОУС, НББОУС)
- Татварын бүртгэл
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг асуудлууд болон бусад асуудлыг шинэчлэх шаардлагатай байсан тул даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/901 дугаар тушаалаар НБББББ-ийг баталж 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс дагаж мөрдөхөөр шийдвэрлэжээ.

Шинээр батлагдсан бодлогын баримт бичгийг дагаж мөрдөх бэлтгэл ажлын хүрээнд тайлант онд систем хоорондын тооцооноос үүссэн авлага өглөгийг хааж тайлант үеийн ашиг алдагдлаар бүртгэсэн байна.

Салбарын хэмжээнд 2001-2017 он хүртэл Инфо системс ХХК-ийн санхүү бүртгэлийн Макс програмыг ашиглаж байсан. 2015 оны 09 дүгээр сард “Санхүүгийн цогц иж бүрэн програм нийлүүлж суурилуулах” гэрээг Интерактив ХХК-тай байгуулж 2016 оноос туршилтын журмаар Веритех програмыг ашиглаж 2017 онд Веритех програмаар тайлант онд санхүүгийн тайланг гаргасан ба тус програмын давуу талууд:

1. Цахим орчинд салбар бүрийн анхан шатны журнал бичилтийг нэгтгэлийн нягтлан бодогч бүрэн хянах боломжтой
2. Мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулга тайлангууд бүрэн нэгтгэгддэг
3. Мөнгөн болон аккруэл суурьт шалгах баланс гаргадаг
4. Санхүүгийн гүйлгээнүүд төлөвлөлтийн програм уруу гүйцэд татагдаж гүйлгээ гарсан тухай бүрд нь төлөвлөгөө гүйцэтгэлийг харьцуулах боломжтой
5. Захиргааны албанаас ажилтны мэдээлэл татагдаж цалингийн програмтай холбогдсон
6. Мөнгөний нарийвчлалын зөрүү үүсдэггүй гэх мэт.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг гүйцэтгэлээ.

1.6 Дотоод хяналт

Бид Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 А/728 дугаар тушаалаар Дотоод аудитын албаны бүтэц орон тоог 7 ажилтантайгаар баталсан ба 2017 оны А/224 тоот тушаалаар 1 орон тоогоор нэмэгдүүлсэн. Мөн даргын Б/15, Б/16 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны 2 ажилтаныг тус албанд шилжүүлэн ажиллуулж нийт 10 ажилтантай дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ, нисэхийн аюулгүй ажиллагаа гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Дотоод аудитын алба нь 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан албаны даргын үр дүнгийн гэрээнд тусгагдаж үр дүнгийн гэрээний биелэлт 93.4 хувьтай байна.

Тус албанаас тайлант онд 17 нэгжид төлөвлөгөөт 9, төлөвлөгөөт бус 15 хяналт шалгалт хийж 5,574.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж 294 зөвлөмж өгч ажилласан байна. Шаардлагатай тохиолдолд ИНЕГ-ын даргын тушаалаар үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг ба зөвлөмжийн хэрэгжилт 90.4 хувийн биелэлттэй байна.

1.7 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Иргэний нисэхийн ерөнхий газрын Агентлагийн төсвийг улсын төсвөөс 3,164.3 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 3,142.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 22.0 сая төгрөгөөр дутуу буюу 99.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт зардлын 81.4 хувь буюу 2,558.9 сая төгрөг цалингийн зардал, бусад урсгал зардал 18.6 хувь буюу 583.3 сая төгрөг тус тус байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгө оруулалтаас 4,323.5 сая төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэн санхүүжигдсэнийг бүртгэн тайлагнасан байна.

Иргэний нисэхийн харьяа үйлдвэрлэлийн албадын 2017 оны төсвийн орлого, зардлын төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 266/385 дугаар тушаалаар тодотгож 258,119.2 сая төгрөгийн орлого, 113,198.2 сая төгрөгийн урсгал зардал, төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг 144,921.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Үүнд:


- Өнгөрөлтийн орлого (навигаци) 231,083.8 сая төгрөг
- Буулт хөөрөлтийн орлого 8,211.0 сая төгрөг
- Зорчигч үйлчилгээний орлого 8,975.0 сая төгрөг
- Бусад орлогоос 8,849.4 сая төгрөг нийт 258,119.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр байна.

Тайлант онд орлого 8.4 хувь буюу 21,734.3 сая төгрөгөөр давж 279,583.5 сая төгрөг, зардлын гүйцэтгэл 99.8 хувь буюу 258,634.8 сая төгрөгөөс улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогод 147,604.9 сая төгрөгийг төвлөрүүлж 2,683.9 сая төгрөг буюу 1.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Мөн Зам, тээврийн хөгжлийн сайд тушаал болон ИНЕГ-ын даргын баталсан төлөвлөгөөгөөр нийт 28,974.3 сая төгрөгийн 136 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдсанаас 11,946.8 сая төгрөгийн 95 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн харуулбал:

| № | Тушаал гаргасан эрх бүхий албан тушаалтан, дугаар | Санхүүжүүлэх эх үүсвэр | Төсөл, арга хэмжээний зориулалт | Төсөв | | Гүйцэтгэл | |
|---|--|------------------------|--|-------|----------|-----------|---------|
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2017 оны батлагдсан төсвөөс ИНЕГ-ын даргын баталсан төлөвлөгөө | Урсгал зардал | ТБОНӨБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах төсөл арга хэмжээнүүд | 77 | 13,857.7 | 66 | 7,237.2 |
| 2 | Зам, тээврийн хөгжлийн сайдын 85 дугаар тушаал | Улсын төсөв | “АСЕМ-ын чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах зориулалттай тоног төхөөрөмж” | 20 | 2,890.3 | 15 | 2,398.2 |



| | | | | | | | |
|---|---|--------------|--|------------|-----------------|-----------|-----------------|
| 3 | Зам, тээврийн хөгжлийн сайдын 191 дүгээр тушаал | Улсын төсөв | Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ | 10 | 2,895.4 | 5 | 1,444.7 |
| 4 | Зам, тээврийн хөгжлийн сайдын 209 дүгээр тушаал | Цэвэр ашгаас | Хөрөнгө оруулалтын ажлууд | 29 | 9,330.9 | 9 | 866.7 |
| | Нийт | | | 136 | 28,974.3 | 95 | 11,946.8 |

1.8 Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (хагас, бүтэн жилээр, улирал бүр, сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (хагас, бүтэн жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (хагас, бүтэн жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (хагас, бүтэн жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)

1.9 Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт 31, хяналтын 11 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 26 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэж үр дүнг гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан.

1.10 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

1.10.1 Харьяа газруудад нийт 3,262.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна


Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 20 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 15 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 4 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 6,082.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,819.0 сая төгрөгийн алдааг залруулж 2.4 сая төгрөгийн акт тогтоож, 2,374.3 сая төгрөгийн албан шаардлага, 885.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад арга хэмжээ авч ажиллах, харьяа газруудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах

1.10.2 Аймаг орон нутгийн нисэх буудлууд санхүүгийн тайлангаа батлагдсан маягтаар гаргаагүй байна

Аймаг орон нутгийн нисэх буудлууд санхүүгийн тайлангаа “Маягт загвар батлах тухай” Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх журмын дагуу тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Салбаруудын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу гаргуулан авч нэгтгэж байх, зөвлөмж өгөх



1.10.3 Үр ашиггүй сургалтын зардал гаргасан байна

Мэргэжлийн сургалтад зориулж 2017 оны 8 дугаар сард Гүрэн дээд сургуультай 180 ажилтанд сургалт зохион байгуулахаар сургалтын төлбөрт нэг ажилтанд дунджаар 2-3 сая төгрөгийн төлбөр төлөхөөр нийт 640.0 сая төгрөгийн гэрээг хийсэн боловч гэрээний хугацаа дууссан байхад гүйцэтгэлээр 160 хүн сургалтад хамрагдсан ба үүний 7 ажилтан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээ, 133 ажилтан Гүрэн дээд сургуулийн гэрчилгээ авсан нь гэрээнд заасан **"олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат бүхий сургалт"** гэсэн шалгуур хангагдаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах, зөвлөмж өгөх

1.10.4 Шүүхийн шийдвэрийн дагуу нийт 449.5 сая төгрөг төлсөн байна

Тайлант онд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болон цалингийн маргаантай холбоотой 15 хүнд 215.7 сая төгрөг, 1 хүнд 110.8 сая төгрөгийн орон сууцны төлбөр, хөрөнгө оруулалтын гэрээний үүргийн биелэлттэй холбоотой 3 байгууллагад 123.0 сая төгрөг нийт 449.5 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах, албан шаардлага өгөх

1.10.5 Сэргээн засах амралтын газар олон жил болсон авлагыг барагдуулаагүй байна

Сэргээн засах амралтын санхүүгийн тайланд нийт 28 байгууллага, хувь хүнтэй холбоотой 26.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна. Үүнээс 27 байгууллага хувь хүнтэй холбоотой 11.6 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогчгүй авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллаж авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, албан шаардлага өгөх

1.10.6 Сэргээн засах амралтын газрын хөрөнгө дутагдсан байна

Сэргээн засах амралтын газарт 2017 оны 8 дугаар сарын 27-нд хулгай орж 3 нэр төрлийн 4 ширхэг 7.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 622.3 мянган төгрөгийн бэлэн мөнгөн алдагдсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй" дэх хэсэгт "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;" мөн хуулийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Салбарын хэмжээнд үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, зөвлөмж өгөх

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1.10.7 Сэргээн засах амралтын газрын мөнгөн гүйлгээний тайлан санхүүгийн програмын тохиргоотой холбоотойгоор орлогыг давхардуулж тайлагнасан байна

Сэргээн засах амралтын газрын мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн програмын тохиргоотой холбоотойгоор кассын орлогыг харилцах дансанд шилжүүлсэн 169.9 сая төгрөгөөр бусад орлого илүү илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4-д "үнэн зөв байх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Мөнгөн гүйлгээний тайланг үнэн зөв тайлагнаж байх, санхүүгийн програмд тохиргоо хийлгэх, дараагийн аудитаар хэрэгжилтийг үзэх

1.10.8 Хөрөнгө оруулалтын ажлын гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээн аваагүй байна

Нислэг хөдөлгөөний програм хангамжид өргөтгөл хийхээр Indra Sisitemas, SA компанитай 2016 онд 397.9 сая төгрөгөөр байгуулсан гэрээт ажлын хугацаа дууссан боловч хөрөнгийг хүлээн аваагүй авлагаар бүтгэсэн байна

Шийдвэрлэсэн: Завсрын аудитаар албан шаардлага өгч ИНЕГ-ын даргын 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/118 дугаар тушаалаар уг хөрөнгө оруулалтын ажлын туршилт шалгалтын хугацааг сунгасан. Техник хангалт навигацийн үйлчилгээний албаны инженерийн туршилт шалгалтын ажлын дүгнэлтээр програм хангамжийн үл тохирлууд бүрэн засварлагдаагүй тул нийлүүлэгч байгууллага өөрсдийн зардлаар 3-4 сард мэргэжилтэн явуулж ажиллах талаар харилцан тохиролцоонд хүрсэн байна. Програм хангамжийг хүлээн авах ажлыг 2 улиралд багтаан хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа тул биелэлтийг 90 хувьтай хэрэгжиж байгаа гэж дүгнэсэн.

1.10.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ажил дуусаагүй, авлагын дансанд бүртгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 аймгийн гэрэл суултын систем суурилуулах тоног төхөөрөмж худалдан авах ажлын гэрээг 2012 онд ESDR Elictronic Pty Ltd компанитай, байгуулсан боловч үндсэн зурвасын ажил дуусаагүйгээс тоног төхөөрөмж бүрэн суурилагдаагүй Говь-Алтай аймагт 85 хувьтай, 2 аймгийн тоног төхөөрөмж аймгуудын агуулахад хадгалагдаж, нийлүүлэгч компани гэрээ цуцлах санал ирүүлсэн ба тус хөрөнгө оруулалтын ажлаас үүссэн 2,891.1 сая төгрөгийн авлага шийдвэрлэгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" , Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: Завсрын аудитаар албан шаардлага өгч 2012 онд ESDR Elictronic Pty Ltd компанитай хийсэн гэрээг дуусгавар болгож ИНЕГ-ын даргын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/130 дугаар тушаалаар Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн нисэх буудлын гэрэл суултын системийн битүүмжилсэн эд ангийг хүлээн авах ажлын хэсэг байгуулж биелэлтийг 4 дүгээр сарын 15-ны дотор тайлагнахаар ажиллаж байгааг холбогдох баримтыг аудитын явцад авч албан шаардлагын биелэлтийг 60 хувьтай хэрэгжиж байгаа гэж дүгнэсэн.

1.10.10 Сэргээн засалт амралтын газарт АСЕМ зохион байгуулагдахад шилжиж ирсэн хөрөнгө дутагдсан байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИДГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Ази-Европын дээд түвшний 11 дүгээр чуулга уулзалтыг зохион байгуулах ажлын хүрээнд худалдан авсан хөрөнгөнөөс Иргэний нисэхийн харьяа Сэргээн засах амралтын баазад Гадаад хэргийн яамнаас шилжүүлэн өгсөн 36.8 сая төгрөгийн тавилгаас 2 нэр төрлийн 10 ширхэг 2.8 сая төгрөгийн тавилга дутсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй” 1 дэх заалт “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;”, и мөн хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Завсрын аудитаар акт тогтоосныг аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлж актын биелэлт 100 хувьтай байна.

1.10.11 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийн өглөгийн үлдэгдэл байна

Хөрөнгө оруулалтын ажлаас барьцаанд суутган авч өглөгөөр бүртгэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн гэрээт ажлын гүйцэтгэгч 28 аж ахуйн нэгж байгууллагын 431.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжсэн гэрээт ажлын гүйцэтгэгч 68 аж ахуйн нэгж байгууллагын 474.2 сая төгрөг нийт 96 аж, ахуйн нэгж, байгууллагатай холбоотой 906.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөг байна. Эдгээр хөрөнгө оруулалтын ажлууд нь 2010-2014 онд хэрэгжсэн ажлын гүйцэтгэлтэй, гэрээ дүгнэсэн акттай, гэрээнд заасан баталгаат хугацаа Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанаас хэтэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, мөн хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Завсрын аудитаар 908.8 сая төгрөгийн тогтоосон актаас 805.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж 89.0 хувийн биелэлттэй байна.

1.11 Залруулагдаагүй алдааны талаарх тайлбар

Аудитаар нийт 2,989.6 сая төгрөгийн залруулах боломжтой алдаа илэрснээс 2,819.7 сая төгрөгийг залруулж, санхүүгийн програмын тохиргоотой холбоотой 169.9 сая төгрөгийн алдааг дараагийн тайлангийн аудитаар залруулсан байхаар тохиролцсон.

1.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Татварын ерөнхий газрын дэргэдэх Улсын төсвийн орлого хяналтын газраас хийсэн хяналт шалгалтаар татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлыг хасаж татвар ногдох орлогыг бууруулсан, оршин суугч бус этгээдээс НӨАТ, ААНОАТ аваагүй, биет бус хөрөнгийг татварын зорилгоор элэгдүүлээгүй, тэтгэлгийн зардлаас ХХОАТ суутгаагүй, НӨАТ-ыг хуулийн хугацаанд төлөөгүй гэх мэт бүртгэл тайлагналтай холбоотой 5,654.3 сая төгрөгийн зөрчилд 679.4 сая төгрөгийн нөхөн татвар 226.1 сая төгрөгийн торгууль, 216.6 сая төгрөгийн алданги нийт 1,122.1 сая төгрөгийн төлбөр ногдуулсан байна.

Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яамны хамтарсан 2012-2017 оны 3 дугаар улирал хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар олон жил болсон дуусаагүй барилга, орон сууцны хөнгөлөлт, сургалтын төлбөр, татварын актыг барагдуулахдаа хувь хүнээс суутган аваагүй, хууль журам мөрдөөгүй худалдан авалт, баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээтэй холбоотой зөрчилд нийт 33,868.1 сая төгрөг, 50.2 мянган ам доллар, 21.2 мянган Австрали доллар, 5.7 мянган еврогийн 4 албан шаардлага өгсөн. Мөн гадаад оюутнуудын

сургалтын төлбөр, хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой илүү олгосон гадаад томилолт, зориулалт бусаар зарцуулсан зөрчилд нийт 1,580.0 сая төгрөг, 164.4 мянган ам, долларын акт тогтоосон байна.

Тайлант онд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болон цалингийн маргаанд 15 хүнд 215.7 сая төгрөг, орон сууцтай холбоотой 1 хүнд 110.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын гэрээний үүргийн биелэлттэй холбоотой 3 байгууллагад 123.0 сая төгрөг нийт 449.5 сая төгрөг, шинэ нисэх буудлын дулааны төлбөр төлөөгүйгээс үндсэн төлбөрт 246.0 сая, хохиролд 28.5 сая нийт 251.1 сая төгрөгийг зарцуулсан. Мөн Үндэсний аудитын газрын актаар 2015 оны ногдол ашиг 1,462.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

1.13 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дуусаагүй барилга дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байсан:

- 2011 онд Үүрэг трейд ХХК-тай байгуулсан Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилга 11,322.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба тус хөрөнгө оруулалтын ажил тодорхой шалтгаануудын улмаас зогсож гэрээний үүрэг хангагдахгүй байсныг захиалагч, гүйцэтгэгч нар харилцан тохиролцож 4,399.9 сая төгрөгт багтаан ажлыг үргэлжлүүлэхээр,
- 2008 онд Хурдны зам ХХК-тай байгуулсан Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих 8,327.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба тус хөрөнгө оруулалтын ажил зогсож гэрээний үүрэг хангагдахгүй байсныг захиалагч, гүйцэтгэгч нар харилцан тохиролцож ажлыг үргэлжлүүлэхээр тус тус Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 137 дугаар тушаалаар цэвэр ашгаас санхүүжүүлэхээр 2,000.0 сая төгрөг тусгасан байгааг дараагийн аудитаар авч үзнэ.

Мөн Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын ашиглалтын өмнөх захиргааны бүтэц, орон тоо болон цалингийн зардал, Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн тооцоолол, хөрөнгөнд биет тооллого хийх, элэгдлийн зардлыг давтан тооцох, хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний батлагдсан төсөв, гүйцэтгэлийг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу явуулж холбогдох хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгасан зэрэг ажлуудыг гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй болно.

1.14 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛНИЙН НЭГТГЭЛ

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 20 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 15 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 4 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар салбарын хэмжээнд харьяа байгууллагуудад 6,082.0 сая төгрөг, төвлөрүүлэн захирагчийн аудитаар 961.5 сая төгрөг, түүврийн байгууллагад 214.8 сая төгрөг, завсрын аудитаар 4,197.8 сая төгрөг нийт 11,456.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,819.7 сая төгрөгийн алдааг залруулж, залруулах боломжгүй 8,466.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6,150.2 сая төгрөгийн албан шаардлага, 911.2 сая төгрөгийн акт, 1,405.1 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

1.15 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар салбарын хэмжээнд 340,696.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 324,703.3 сая төгрөг алдааг залруулж 10,437.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага 22.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,463.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Үүнээс зөвлөмж 87.5 хувь, албан шаардлага 80.3 хувь, акт 84.4 хувийн тус тус биелэлттэй байна.

Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 326,866.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 324,638.7 сая төгрөгийн алдааг залруулж 2,071.3 сая төгрөгийн зөрчилд Энч аудит ХХК албан шаардлагаар өгсөн тул 156.1 сая төгрөгийн зөвлөмж өгснийг 75 хувьтай биелүүлсэн байна.

Мөн 2017 оны 3 улирлын байдлаарх санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 4,585.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 911.2 сая төгрөгийн акт, 3,289.0 сая төгрөгийн албан шаардлага, 357.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн. Үүнээс залруулах боломжгүй 357.2 сая төгрөгийн зөрчлийг Үйлдвэрлэл, нисэх хөдөлгөөний албаны 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлагаар хүргүүлсэн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой өгсөн албан шаардлага 75 хувь, тогтоосон актаас 805.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж 89.0 хувийн тус тус биелэлттэй байна.

1.16 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор тооцов.

Төлөвлөлтийн үед үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 289,929.1 сая төгрөгийн 1.5 хувь буюу 4,348.9 сая төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөлт ороогүй.

Мөн өмнөх оны аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан, завсрын аудитаар нийт 4,585.8 сая төгрөгийн зөрчилд акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн, НБББББ, санхүүгийн програм шинэчлэгдсэн зэргийг харгалзан эрсдэлийг дунд гэж төлөвлөж материаллаг байдлын тооцох түвшинг 1.5 хувиар сонгосон.

Төлөвлөлтийн үед шинж чанар, орчин нөхцөлийн хувьд материаллаг шинжтэй зүйл байж болзошгүй гэж үзсэн ба гүйцэтгэлээр шинж чанар, орчин нөхцөлийн хувь материаллаг шинжтэй алдаа, зөрчил илрээгүй болно.

1.17 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

1.18 Аудитын үр өгөөж

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 911.2 сая төгрөгийн акт тогтоож улсын төсөвт 908.8 сая төгрөг төвлөрүүлсэн, 2.8 сая төгрөгийн дутагдсан хөрөнгийн хохирлыг барагдуулсан. Албан шаардлагаар хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс үүссэн 5,700.5 сая төгрөгийн авлагыг бууруулах, 449.5 сая төгрөгийн зөвлөмж өгч цаашид үр ашиггүй зардал гаргахгүй байх зэрэг арга хэмжээ авснаар санхүүгийн үр өгөөж үүснэ гэж тооцлоо.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг Байгууллагын удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд санхүүгийн хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан байна.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн алба болон дотоод аудитын газрын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



| | |
|--|---|
| Асуудал 1: Үр ашиггүй сургалтын зардал гаргасан | Тэргүүлэх ач холбогдол №1 |
| <p><u>ҮАГ-ын ажиглалт</u> Мэргэжлийн сургалтад зориулж 2017 оны 8 дугаар сард Гүрэн дээд сургуультай 180 ажилтанд сургалт зохион байгуулахаар сургалтын төлбөрт нэг ажилтанд дунджаар 2-3 сая төгрөгийн төлбөр төлөхөөр нийт 640.0 сая төгрөгийн гэрээг хийсэн боловч гэрээний хугацаа дууссан байхад гүйцэтгэлээр 160 хүн сургалтад хамрагдсан ба үүний 7 ажилтан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээ, 133 ажилтан Гүрэн дээд сургуулийн гэрчилгээ авсан зохион байгуулах "олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат бүхий сургалт" хангагдахгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p> | <p><u>ҮАГ-ын зөвлөмж</u> Үр ашиггүй зардал гаргахгүй байх, төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах Биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p> |
| <p><u>Эрсдэлүүд</u> Үр ашиггүй зардал ихсэх, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх</p> | <p><u>Удирдлагын хариу</u> Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.</p> |

| | |
|--|---|
| 2.1 Асуудал 2: Харьяа газруудад илэрсэн зөрчлийн талаар | Тэргүүлэх ач холбогдол №1 |
| <p><u>ҮАГ-ын ажиглалт</u> Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 20 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 15 санхүүгийн тайланд зөрчилгүй, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 4 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 6,082.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,819.0 сая төгрөгийн алдааг залруулж 2.4 сая төгрөгийн акт тогтоож, 2,374.3 сая төгрөгийн албан шаардлага, 885.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.</p> | <p><u>ҮАГ-ын зөвлөмж</u> Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад арга хэмжээ авч ажиллах, харьяа газруудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах Биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p> |
| <p><u>Эрсдэлүүд</u> Бүртгэлээр тавих хяналт сул</p> | <p><u>Удирдлагын хариу</u> Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.</p> |



| | |
|---|----------------------------------|
| 2.2 Асуудал 3: Сэргээн засах амралтын газрын хөрөнгө дутагдсан байна | Тэргүүлэх ач холбогдол №1 |
|---|----------------------------------|

ҮАГ-ын ажиглалт

Сэргээн засах амралтын газарт 2017 оны 8 дугаар сарын 27-нд хулгай орж 3 нэр төрлийн 4 ширхэг 7.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 622.3 мянган төгрөгийн бэлэн мөнгөн алдагдсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй" дэх хэсэгт "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;" мөн хуулийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хөрөнгө дутагдах, шамшигдах, бүртгэлээр тавих хяналт сул

ҮАГ-ын зөвлөмж

Салбарын хэмжээнд үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах, зөвлөмж өгөх

Биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Удирдлагын хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

| | |
|---|----------------------------------|
| 2.3 Асуудал 4: Аймаг орон нутгийн санхүүгийн тайлангийн талаар | Тэргүүлэх ач холбогдол №1 |
|---|----------------------------------|

ҮАГ-ын ажиглалт

Аймаг орон нутгийн нисэх буудлууд санхүүгийн тайлангаа "Маягт загвар батлах тухай" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх журмын дагуу бэлтгэн гаргаагүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хяналт сул

ҮАГ-ын зөвлөмж

Салбаруудын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу гаргуулан авч нэгтгэж байх,

Биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Удирдлагын хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.



3 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2016 оны 12-р сарын 31 | 2017 оны 12-р сарын 31 |
|-----------|--|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 95,029,948.6 | 121,059,673.6 |
| 31 | Мөнгөн хөрөнгө | 44,795,664.2 | 66,063,760.3 |
| 33 | Авлага | 43,946,284.5 | 46,055,032.2 |
| 34 | Урьдчилж төлсөн зардал | 163,664.2 | 1,399,603.4 |
| 35 | Бараа материал | 6,118,788.2 | 7,535,730.2 |
| 360 | Бусад эргэлтийн хөрөнгө | 5,547.5 | 5,547.5 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 187,170,990.4 | 179,915,815.7 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 187,170,990.4 | 179,915,815.7 |
| 39200 | Биет хөрөнгө | 155,884,276.8 | 155,960,121.2 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 2,140,649.5 | 1,686,662.1 |
| 39400 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 123,948.0 | 571,198.8 |
| 39500 | Дуусаагүй барилга | 29,022,116.1 | 21,697,833.6 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 282,200,939.0 | 300,975,489.2 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 10,704,524.3 | 9,433,445.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 8,311,955.6 | 6,065,796.1 |
| 41300 | Өглөг | 8,156,921.2 | 6,012,883.9 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 155,034.4 | 52,912.1 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,392,568.7 | 3,367,649.4 |
| 42229 | Хойшлогдсон татварын өглөг | 2,392,568.7 | 0.0 |
| 42242 | Урьдчилж орсон орлого /ХО/ | 0.0 | 3,367,649.4 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 271,496,414.7 | 291,542,043.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 271,496,414.7 | 291,542,043.8 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 225,569,216.1 | 225,569,216.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 45,927,198.6 | 62,835,425.8 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 282,200,939.0 | 300,975,489.2 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2016 оны 12-р сарын 31 | 2017 оны 12-р сарын 31 |
|------------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 243,030,530.8 | 281,692,293.5 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 243,030,530.8 | 281,692,293.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 243,030,530.8 | 281,692,293.5 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 221,540,668.7 | 247,623,183.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 221,540,668.7 | 247,623,183.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 105,696,268.7 | 100,018,267.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 44,876,400.1 | 55,039,112.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,167,563.9 | 6,242,685.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,204,974.4 | 7,283,645.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,819,962.9 | 1,423,694.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,959,642.2 | 3,925,401.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,001,655.3 | 796,175.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,666,070.0 | 25,307,552.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 115,844,400.0 | 147,604,916.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 21,489,862.1 | 34,069,110.2 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 15,669,804.2 | 8,236,811.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 17,221,624.5 | 15,620,274.1 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 19,938,041.8 | 26,685,647.0 |
| VII | Орлогын татварын зардал | 6,608,075.7 | 5,678,371.2 |
| VIII | Тайлант үеийн үр дүн | 13,329,966.1 | 21,007,275.8 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2016 оны 12-р сарын 31 | 2017 оны 12-р сарын 31 |
|-------------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 239,711,484.3 | 277,709,709.5 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 239,711,484.3 | 277,709,709.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 239,711,484.3 | 277,709,709.5 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 204,557,435.5 | 251,589,153.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 204,557,435.5 | 251,589,153.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 204,557,435.5 | 251,589,153.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 48,428,333.9 | 51,450,665.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,169,950.1 | 10,853,970.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,204,974.4 | 6,446,483.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,036,722.3 | 5,571,777.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,925,798.2 | 3,750,142.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 129,791,656.5 | 173,516,114.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 35,154,048.9 | 26,120,555.9 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 625,606.4 | 1,698,725.2 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 14,626,581.0 | 6,551,185.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 14,626,581.0 | 6,551,185.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (14,000,974.6) | (4,852,459.9) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 21,153,074.3 | 21,268,096.1 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 23,642,589.9 | 44,795,664.2 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 44,795,664.2 | 66,063,760.3 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөг)

| Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|--|--|-----------------------|------------------------|
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 261,352,989.0 | 0.0 | 261,352,989.0 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (3,186,540.2) | 0.0 | (3,186,540.2) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 258,166,448.7 | 0.0 | 258,166,448.7 |
| Тайлант үеийн үр дүн | 13,329,966.0 | 0.0 | 13,329,966.0 |
| 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 271,496,414.7 | 0.0 | 271,496,414.7 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (4,099,048.6) | 0.0 | (4,099,048.6) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 267,397,366.1 | 0.0 | 267,397,366.1 |
| Тайлант үеийн үр дүн | 21,007,275.8 | 0.0 | 21,007,275.8 |
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 291,542,043.8 | 0.0 | 291,542,043.8 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|-------------------------------------|--------------------------------|--|---------------------|
| Огноо: | Аудитын нэр: | 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит | САГ-2018/18/СТА-ТТЗ |
| 2018.03.23 | | | Сая төгрөгөөр |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Иргэний нисэхийн ерөнхий өвсөр | | Аудитын код: |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|------------|--|--------------|---------------------------------------|--|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант онд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болон цалингийн маргаанд 15 хүнд 215.7 сая төгрөг, орон сууцтай холбоотой 1 хүнд 110.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын гэрээний үүргийн биелэлттэй холбоотой 3 байгууллагад 123.0 сая төгрөг нийт 449.5 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 449.5 | Албан шаардлага | Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга асан | С.Буяндалай Г.Лхагвасүрэн Ц.Эрдэнэбилэг |
| 2 | Сэргээн засах амралтын санхүүгийн тайланд нийт 28 байгууллага, хувь хүнтэй холбоотой 26.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна. Үүнээс 27 байгууллага хувь хүнтэй холбоотой 11.6 сая төгрөгийн авлага тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогчгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 37.4 | Албан шаардлага | Сэргээн засах сувилалын дарга Ахлах нягтлан бодогч | Ж.Амарсүрэн Д.Цэцэгбаяр |
| Дүн | | 486.9 | | | |

